

БАТЛАВ:  
ЗАСАГ ДАРГА  Х.БАТТУЛГА  
ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


Жаварт хошуу

1. Байршил: Дорнод аймгийн Баян-Уул сумын ундны ус, бэлчээрт
  - 1.1 Хөдөөгийн багуудад бэлчээр усжуулах 4 худаг гаргах.
2. Ажлын тодорхойлолт: Сумын хөдөөгийн малчдын бэлчээр усжуулалтанд зориулж инженерийн хийцтэй гүний худаг шинээр гаргана.
  - 2.1 Худгийг шинээр гаргахаас өмнө ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.
  - 2.2 Худгийг цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд хяналт тавих техникийн шаардлага МИС 6088:2011 стандарттай, тусгай зөвшөөрөлтэй, өрөмдлөг, шавхалт, туршилтийн ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгааны үүсгүүрийг сонгон суурилуулах ажлыг гүйцэтгэнэ.
  - 2.3 Монгол улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө.
    - Ажлын иж бүрдэл цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуургын насос зэргийг хүлээж авах ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.
    - "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай орон нутгийн өмчид тусгуулна.
    - Шинээр худаг өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ. Ус багтай бол өрөмдөх шаардлаггүй, дахин хайгуул хийнэ.
    - Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ. Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
    - Худгийн техникийн паспортыг хөтөлж, аймгийн БОАЖГазраар баталгаажуулан, сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгнө.
    - Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн актын хамт үйлдэж аймаг, суманд хүлээлгэн өгнө.

- Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна. Худгийн усны шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.
- 2.4 Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хариуг худгийн паспортод хавсаргасан байх
- 2.5 Худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлийг худгийн ажил эхлэхээс өмнө сумын Засаг даргын захирамжаар зөвшөөрөл олгоно.
- 3. Худгийн үзүүлэлт болон хөрөнгө оруулалт, гүйцэтгэгчийн мэдээллийг харуулсан гадна хаягийг холбогдох журмын дагуу хийж хадна.

Техникийн тодорхойлолт боловсруулсан:

Засаг даргын орлогч

  
С.Цэрэнбадрал

Газрын даамал

  
П.Отгон-Иш